

МОНГОЛ АЛТАЙН БҮС НУТГИЙН АРХЕОЛОГИЙН СОЁЛУУД

Д.ЭРДЭНЭБААТАР¹, А.А.КОВАЛЕВ²

¹ШУА-ийн Түүхийн хүрээлэн

e-mail: ediiatajav@yahoo.com

²ОХУ-ын Санкт-Петербургийн Их Сургуулийн Археологийн тэнхим

e-mail chemurchek@mail.ru

Түлхүүр үгс: Хүрэл зэвсэг, чемурчек, мөнххайрхан, хиригсүүр, були, оршуулгын зан үйл, мөнгөн тайга, шоргоолжин були

Өгүүллийн товч агуулга: Монгол-Оросын хамтарсан “Төв Азийн археологийн шинжилгээ” төслийн хүрээнд Монгол орны Алтайн нурууны бүс нутагт хүрэл-төмрийн эрин үед эртний овог аймгуудын үлдээсэн археологийн дурсгалуудыг судлах явцад монгол нутагт МЭӨ III-I мянган жилийн тэртээд холбогдох зарим оршуулгын зан үйл бүхий дурсгалууд урьд өмнө судлагдаж байгаагүй шинэ дурсгал төдийгүй анх удаа монгол нутгаас илрэн олдсоноороо археологийн судалгаанд шинэ эх сурвалж, шинэ мэдээлэл болж орж байгаа юм. Тухайлбал, “Афанасьевын соёл”, “Чемурचेкийн соёл”, “Мөнххайрханы соёл”, “Байтагийн соёл” зэрэг нь Алтайн бүс нутагт нэг нь нөгөөгөөсөө угсаа-соёлын эрс ялгаа бүхий эртний овог аймаг байсны тодорхой жишээ баримт болж байгаа юм.

Монгол улсын ШУА-ийн Түүхийн хүрээлэн, Улаанбаатарын их сургууль, ОХУ-ын Санкт-Петербургийн их сургуулийн гурвалсан хамтын ажиллагааны гэрээний дагуу 2001-2005 онуудад “Төв Азийн археологийн шинжилгээ” төслийн хүрээнд Монгол орны Ховд, Баян-Өлгий, Говь-Алтай, Баянхонгор аймгуудын нутагт тодруулбал Алтайн нурууны өвөр болон арын бүс нутгаар хүрэл болон төмрийн түрүү үеийн түүхэнд холбогдох оршуулгын зан үйлийн дурсгалуудын ямар хэлбэрүүд байгааг эрэл хайгуул хийн судлах ажлыг төлөвлөн хайгуул судалгааны ажлаа явуулсан юм. Уг “Төв Азийн археологийн шинжилгээ” төслийн олон улсын хамтарсан археологийн шинжилгээний анги нь Монгол Алтайн бүс нутаг дахь МЭӨ III-I мянган жилийн тэртээд амьдарч байсан эртний овог аймгуудын түүх-соёлын нийтлэг болон ялгаатай шинжийг тодруулах зорилгоор хайгуул, малтлага судалгааны ажлыг хийж ирсэн болно. Өнгөрсөн хугацаанд явуулсан хайгуул судалгааны ажлын үр дүнд Монгол орны нутаг дахь Алтайн бүс нутгаас “Чемурчекийн соёл” хэмээх шинэ дурсгалыг илрүүлэн олсон ба “Афанасьевын соёл”-ын болоод “Пазырыкийн соёл”-ын зүүн өмнөд хязгаарыг харуулж болох булш, цогцолборуудыг илрүүлэн олж тодорхойлсон юм. Мөн хүрэл зэвсгийн дунд үеийн түүхэнд холбогдох “Мөнххайрханы соёл”, хүрэл зэвсгийн хожуу үеийн түүхэнд холбогдох “Байтагийн соёл” зэрэг шинэ хэлбэрийн оршуулгын байгууламж, зан үйл байгаа болохыг илрүүлэн олж судалсан ба эдгээр дурсгалуудын тархалт, он цагийн хамаарлыг тодорхойлон Монгол Алтайн бүс нутагт эрт болон дунд, хожуу хүрэл зэвсгийн үе болоод төмрийн түрүү үеийн түүхэнд холбогдох эртний овог

аймгуудын үлдээсэн нэг нь нөгөөгөөсөө ялгарах соёлын онцлог ялгааг тодруулахын зэрэгцээ эртний скифийн соёлын улбаа, “Аржаны соёл”-ын өмнөх үеийн овог аймгуудын соёлын уламжлал хэрхэн хувьсаж өөрчлөгдсөн болохыг харж болохоор судалгааны баримтуудыг хуримтлуулсан хэмээн үзэж болно.

2004 онд Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутаг Хар ямаатын голын хөндий дэх Хуурай говь хэмээх газраас илрүүлэн олж тэмдэглэсэн бүлэг археологийн дурсгалуудыг судлах явцад 1-р булш бол “Афанасьев соёл”-ын булш болох нь мэдэгдсэн юм. Энэ булш 16 метр дугуй голчтой, хавтгай чулуун дараастай, дараас чулуунуудыг 1 метр орчим өндөртэй, 7-10 см зузаантай нимгэн хавтгай чулуунуудаар хашлага хийж босоогоор нь тавьсан (**Зураг 1**). Булшны зүүн хэсгийн хашлага чулуунууд 2 метр өндөртэй байсан бөгөөд газарт нилээд гүн ухаж суулгасан, хожим мөн өөрөө байгалийн жамаар шороогоор их дарагдсан байна. Булшны дараас чулууны дор, төв хэсэгт тэгш дөрвөлжин хэлбэртэй 2 метр гүнтэй оршуулгын нүх, малтлагын явцад илэрч олдсон ба толгойг нь зүүн тийш хандуулан, нуруугаар тэнэгэр байдалтай дээш харуулан тавьсан эрэгтэй хүний болоод хүүхдийг оршуулсан болох нь цэвэрлэгээний дараа илэрсэн юм (**Зураг 2**).

Энэхүү хоёр хүнийг тэрэгний тэвшний ёроолоор хучиж тагласан болох нь мэдэгдлээ. Оршуулгын зан үйлд дагалдуулан хүрэл хутга, хүрэл зүү, ясан сумын зэв (**Зураг 3**), “афанасьевын соёл”-ын уламжлалт загвар болох өндгөн ёроолтой алтай хэлбэрийн шавар ваар (**Зураг 4**), богийн шагай зэргийг тавьжээ. Ваарыг эрэгтэй хүн болоод хүүхдийн дунд тавьсан нь шороонд дарагдан эвдэрчээ. Булшнаас гарсан нүүрс, мод, хүний яс зэргээс долоон удаагийн дээж авч, он цаг тогтоох лабораторийн задлан шинжилгээ (Эдгээр шинжилгээнүүдийг Санкт-Петербургийн Эдийн соёлыг судлах хүрээлэнгийн лабораторид хийсэн болно) хийж үзэхэд МЭӨ III мянган жилийн хоёрдугаар хагасын төгсгөлд холбогдох нь тодорхой боллоо. Яг ийм хэлбэрийн “афанасьевын соёл”-д холбогдох хавтгай чулуугаар босоо хашлага хийсэн багавтар хэмжээтэй дугуй хэлбэрийн хоёр булш Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутаг Согоо голын зүүн эргийн дэнж дээр Хөндий говь хэмээх газар бас байгааг илрүүлэн олсон юм.

“Төв Азийн археологийн шинжилгээ” төслийн олон улсын хамтарсан хээрийн шинжилгээний ангийн судалгааны явцад шинээр гаргасан нэг чухал үр дүнгийн нэг бол МЭӨ III мянган жилийн дунд үед Монгол Алтайн нурууны зүүн хэсэгт эдүгээгийн Монгол орны нутагт “чемурчекийн соёл”-ыг үлдээгч овог аймаг нүүдэллэн ирсэн болох нь тодорхой байна. “Чемурчекийн соёл”-ыг үлдээгчдийн дурсгалыг үүнээс өмнө БНХАУ-ын Шинжан-Уйгурын нутагт явуулсан хээрийн ангид судлахдаа (Kovalev, 2000; Ковалев, 2005) зөвхөн хүн чулуун хөшөөнүүдийн хэлбэр, тархалтуудын талаар бичжээ. Уг соёлын гол үндсэн шинж болох хүн чулуун хөшөөний талаар өөр саналтай судлаач бас байгааг тэмдэглэх хэрэгтэй (Hayashi, 2005). Бидний хийсэн малтлага судалгааны ажил бол энэ соёлыг үлдээгч овог аймгийн оршуулгын байгууламж болон оршуулгын зан үйлийг хамтад нь дэлгэрэнгүй авч үзсэн явдал юм.

Ховд аймгийн Булган сумын нутаг Ягшийн хөдөө (**Зураг 5**), Хэвийн ам, Буурал харын ар зэрэг газруудаас нийт зургаан булш, Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын Хул уул, Хуурай говь, Хөндий говь, Хар хошуу, Цагаан голын зүүн эргээс тус бүр нэг нэг булш илрүүлэн олсон бөгөөд эдгээрээс Цагаан голын зүүн эрэгт илэрсэн булшнаас бусдыг малтан шинжилсэн юм.

Баян-Өлгий аймгийн нутгаас илэрч олдсон “чемурчекийн соёл”-ын булшнууд нь тэгш дөрвөлжин хэлбэрийн чулуун хүрээтэй, голдоо баруунаас зүүн тийш сунасан чиглэлтэй оршуулгын нүхтэй байна. Хул уул болон Хар хошуу, Хуурай говийн “чемурчекийн” булшнуудын чулуун хүрээний зүүн гадна талд босоо чулуун хөшөө байгаа болох нь тодорхой байна. Жишээ нь Хул уулын булшны зүүн талд байгаа хөшөө чулуу “хүний нүүрний дүрстэй байхад, Хар хошууны булшны зүүн талд тавьсан хөшөөг улаан зосоор бүхэлд нь будаж шунхдсан байна. Хуурай говиос илэрч олдсон “чемурчекийн” 2-р булш, “афансьевийн соёл”-ын булштай зэрэгцэн байгаа нь уг хоёр соёлыг үлдээгчид ойролцоо цаг хугацаанд Алтайн бүс нутагт ирсэн байж болохоос гадна магадгүй “чемурчекчууд”-ын хүмүүс, “афанасьевчууд”-ын хүн амын бүрэлдэхүүнд багтан явж байсан байж магадгүй. Учир нь “афанасьев”-ын булшны зүүн талд “чемурчекийн” булш зэрэгцээд байгаа төдийгүй хоёр өөр соёлыг илэрхийлж уг хоёр булш, тухайлбал “афанасьевын” булш болоод Хул уулын 1-р булш, Хар хошууны булшнаас гарсан ясан зэвүүд ижил байсан юм.

Түүгээр үл барам уг хоёр булшнаас авсан он цаг тогтоох дээжийг уг булшнуудын нүхнээс илэрсэн нүүрсээр хийсэн (Эдгээр шинжилгээнүүдийг Санкт-Петербургийн Эдийн соёлыг судлах хүрээлэнгийн лабораторид хийсэн болно) бөгөөд уг лабораторийн судалгааны үр дүн хоёр булш хоёулаа ойролцоо цаг хугацааны үед гарсан нь ижил бус хоёр соёл хамтдаа Алтайд нутаглаж байсны баримт болж гарсан байна. Ховд аймгийн Булган сумын нутагт Ягшийн хөдөө хэмээх газар малтан шинжилсэн “чемурчекийн соёл”-ын булшнууд тэр дундаа 3-р булш бол баруунаас зүүн тийш чиглэлтэй тэгш дөрвөлжин хэлбэрийн том чулуун хайрцгаа газарт ухаж суулгаад хүнээ оршуулахдаа бүлгээр нь 10 хүртэл хүмүүсийг хамт оршуулсан байж магадгүй байна.

Газрын хөрснөөс дээш цухуйсан чулуун хайрцагны гадна талаар шороо, чулуугаар дарж булсан байна. Булшны зүүн талд цайвар өнгийн цул боржин чулуугаар хөшөө босгож тавьсан байна. Уг хөшөөг “чемурчекийн соёл”-ын уламжлалт аргаар цоолборлон хийсэн бөгөөд хөшөөнд магнай дээрээ хоёр гүвгэр шулуун зураа бүхий дугуй царайтай, хөмсөг, сахалтай хүнийг дүрслэхдээ булчинлаг цээж, баруун гартаа “таяг”, зүүн гартаа нүм барьж байгаагаар дүрсэлжээ (**Зураг 7**). Хэвийн амны 1-р булшны зүүн талд үүдэвч маягийн чулуун өрлөг хийж, улаан зосоор шунхдаж будсан нимгэн хавтгай чулуугаар хөшөө босгож тавьжээ. Булшныхаа зүүн талд ингэж хөшөө босгож тавьсан булш бидний хайгуул судалгааны үр дүнд Ховд голын ай сав дагуу болоод Буянт голын хөндийд цөөнгүй тохиолдож байна (Ковалев, 2005). Ялангуяа Буянт голын хөндийд явуулсан археологийн хайгуул судалгааны үр дүнд “чемурчекийн соёл”-ын шинэ олдвор бүхий дурсгал илрэн олдсон байна (Тишкин, 2006). Монгол нутагт малтан шинжилсэн “чемурчекийн соёл”-ын булшнуудаас гарсан яс, мод, нүүрс зэрэг нийт 27 дээжинд он цаг тогтоох лабораторийн задлан шинжилгээ хийсэн бөгөөд энэ соёлын холбогдох он цаг МЭӨ II мянган жилийн I зууны сүүлээр хамаарч байна.

2001 онд Ховд аймгийн Мөнххайрхан сумын нутаг Хар говь хэмээх газар хүрэл зэвсгийн хожуу үеийн дурсгал болох хиригсүүрийн ойролцоо оршин байсан дугуй хүрээтэй гурван тахилын байгууламж он цагийн хувьд “чемурчекийн соёл”-д хамаарч байгаа бөгөөд “чемурчекуудын” тахилын байгууламж бололтой байна. Энэ тахилын байгууламжаас гарсан өнгөлөн зассан чулуун зэвсэг 1999 онд Казакстан улсын нутагт малтан шинжилсэн Айна булак -1-ийн “чемурчекийн” 2-р булшнаас олдож байв. Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутаг Хул уулын орчим илэрсэн хүрээтэй хиригсүүр болон Казахстан улсын нутаг Копа-2 гэдэг газар илэрсэн

булшны хүрээний зүүн талд хүний толгойн дүртэй хөшөө чулуу тавьсан нь тохиолдож байна.

Монгол Алтайн бүс нутагт шинээр илэрч олдож буй хүрэл зэвсгийн дунд үеийн түүхэнд холбогдох дурсгалыг 2003 онд “Төв Азийн археологийн шинжилгээ” төслийн олон улсын хамтарсан археологийн шинжилгээний анги Ховд аймгийн Мөнххайрхан сумын нутгаас илрүүлэн олж “Мөнххайрханы соёл” хэмээн нэрлэсэн юм. Улаан говийн үзүүр хэмээх газраас олдсон 1-р булш чулууг дугуй хэлбэрээр нэг үе тэгшлэн өрж тавьсан, дундаж хэмжээ нь ойролцоогоор 2,5-3 метр орчим дугуй голчтой байдаг (**Зураг 9**). Булшны дараас чулуун төв хэсэгт оршуулгын нүх орших ба зууван дугуй хэлбэрийн 1,3 х 1 метр хэмжээтэй нүхийг 1,5 метр гүнтэй ухаж оршуулсан хүнээ чулуугаар хашиж тавьсан байдаг. Хүнээ зүүн хажуугаар нь атийлган хурааж, толгойг нь зүүн тийш хандуулан хэвтүүлэн тавиад, нас барсан хүндээ модон бариултай хүрэл хутга, хүрэл шөвөг, ясан халбага зэргийг дагалдуулан тавьсан байна. Хүнээ хашиж тавьсан чулуунууд хавтгайдуу боловч бөндгөр, хоёр үе давхарлан тавьсан байдаг. Энэ хэлбэр ихэвчлэн жирийн иргэдийн булшны ерөнхий хэлбэр бололтой (**Зураг 10, Зураг 11**).

Ховд аймгийн Мөнххайрхан сумын нутаг Дунд Цэнхэрийн голын хөндийд ийм хэлбэрийн дөрвөн булш малтан шинжилсэн бөгөөд гадаад болон дотоод хэлбэрийн хувьд “Мөнхайрханы соёл”-д хамаарах нь тодорхой байна. Дээрх булшнуудын оршуулгын зан үйл тоногдоноос болж мэдэгдэхгүй болсон байна. Мөнххайрхан сумын нутаг Хатуу давааны 1-р булш, Улаан говийн үзүүрт 1-р болон 2-р булш хүүхдийн оршуулга болох нь тодорхой байна. Улаан говийн үзүүр хэмээх газар орших хамтдаа байсан дөрвөн булшны нэг нь огт хөндөгдөөгүй бусад нь тоногдон эвдэрсэн байсан боловч тэдгээр булшнуудаас гарсан хүний ясанд хийсэн радиокарбоны задлан шинжилгээгээр МЭӨ 1800-1600 жилийн тэртээд холбогдож байна.

Мөн ийм “мөнххайрханы соёл”-д хамаарах гурван булш Мөнххайрханы сумын төвөөс хойших нутгаас хайгуул судалгааны явцад илрэн олдсон юм. 2006 онд “Төв Азийн археологийн шинжилгээ” төслийн олон улсын хамтарсан археологийн шинжилгээний анги Хөвсгөл аймгийн нутгаас “мөнххайрханы соёл”-д хамаарах булш цөөнгүй илрүүлж олсон төдийгүй “язгууртны” хэмээн үзэж болох 38 метр дугуй голчтой булшийг (**Зураг 12**) Хөвсгөл аймгийн Арбулаг сумын нутгаас илрүүлэн олсон бөгөөд нутгийнхан уг булшийг “Цэнгүнжавын гэрийн буурь” хэмээн домоглон нэрлэдэг байна. Энэ булш хэдийгээр тоногдсон боловч, уг булшны хажууд зэрэгцэн байсан дөрвөлжин хэлбэрийн “мөнххайрханы соёл”-д хамаарах булшнаас энэ соёлын үндсэн гол эдийн соёлын шинжийг илэрхийлсэн хүрэл хутга, хүрэл зүү олдсон юм. 2003 онд манай археологийн шинжилгээний ангийн гишүүн А.В.Варенов Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутаг Ховд голын дээд эхэнд мөн яг ийм том дугуй хэлбэрийн хавтгай булш байсныг тэмдэглэсэн байна.

Монгол Алтай дахь хүрэл зэвсгийн хожуу үеийн түүхэнд холбогдох оршуулгын зан үйл бүхий археологийн дурсгалуудад дугуй хүрээтэй, дөрвөн зүгт босоо хөшөө чулуутай, мөн дөрвөлжин хүрээтэй, дөрвөн буландаа хөшөө чулуутай булш, мөн дугуй хүрээтэй булш зэрэг дурсгалууд хамаарах бололтой. Энэ төрлийн дурсгалуудыг өмнө нь судалсан зарим судлаачид тухайн булшны байршлыг тодорхойлон, малтлага хийсэн байдаг боловч ихэнхдээ тэдгээр нь ямар нэг эд өлгийн олдворгүй, он цаг тогтоох радио-карбоны задлан шинжилгээ хийгээгүй орхисон байна (Батмөнх, 2000). Чулуугаар дугуй болон дөрвөлжин хүрээ хийж

түүнийгээ чулуун дараасаар тэгш хавтгайлан тавцан маягаар дүүргэсэн булшинд хүнээ төв хэсэгт нь гүн биш нүхэнд тавьж хавтгай нимгэн чулуугаар хашлага хайрцаг хийж тавьдаг зан үйл бүхий булш Алтайн уулсын ам салаа болгоноос урсан гарч буй том жижиг голын хөндийгээр нилээд элбэг тархсан байдаг. Ийм дөрвөлжин хүрээтэй, газар дээр гүн нүх ухаж, голдоо хавтгайдуу өндөр биш чулуун дараас хийн хүнээ оршуулсан зан үйл бүхий булшийг үүнээс өмнө зарим судлаачид Завхан аймгийн Тосонцэнгэл сумын нутагт малтан шинжилсэн байна (Коновалов и др., 1995).



Зураг 1 Баян-Өлгий аймаг Улаанхус сум
Афанасевийн булш



Зураг 2 Афанасевийн
булшны оршуулгын зан үйл



Зураг 3. Афанасевийн булшнаас
олдсон хүрэл болон ясан эдлэлүүд



Зураг 4. Афанасевийн булшны өндгөн
ёроолтой ваар



Зураг 5 Ховд Булган сум Ягшийн хөдөө,
Чемурчекийн соёлын 1-р булш



Зураг 6 Ховд Булган сум 3-р
булшнаас гарсан чулуун аяга



Зураг 7 Ховд Булган сум, Ягшын хөдөө
1-р булшны хүн чулуун хөшөө



Зураг 8 БНХАУ-ын Алтайн
аймгийн нутаг дахь Чемуракеийн
соёлын хүн чулуун хөшөө



Зураг 9 Ховд Мөнххайрхан сум,
Улаан говийн үзүүрийн 1-р булш



Зураг 10 Ховд Мөнххайрхан сум
Улаан говийн үзүүрийн 1-р булшны
оршуулгын зан үйл



Зураг 11. Ховд Мөнххайрхан сум, Улаан говийн
үзүүрийн 1-р булшнаас олдсон хүрэл хутга,
зүү, ясан халбага



Зураг 12 Хөвсгөл Арбулаг сум
Галбаагийн үзүүрийн булш



Зураг 13. Ховд Мөнххайрхан сум Хөх толгойн
1-р булш



Зураг 14 Ховд Мөнххайрхан сум
Хөх толгойн 2-р булш

Бидний археологийн судалгаа хийсэн Ховд аймгийн Мөнххайрхан сумын нутаг Хөх толгой 3-р болон (**Зураг 14**) 9-р булш, Тэлэнгэдийн амны 3-р булш (**Зураг 16**), Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутаг Хул уулын 2-р булш, Ховд аймгийн Булган сумын Хужиртын голын 2-р цогцолбор булшнуудын 1-р булш зэрэгт хүнээ баруун хажуугаар тэнэгэр байдалтай хэвтүүлэн, толгойг нь баруун тийш хандуулан гүн биш нүх газарт хонхойлгон хийж тавихдаа хавтгай нимгэн чулуугаар хашлага хайрцаг хийж мөн хавтгай чулуугаар таг болгон тагласан байдалтай байв. Радио-карбоны задлан шинжилгээний дүнгээс харахад эдгээр булшнууд нь МЭӨ II мянган жилийн II хагаст холбогдож буй бөгөөд булшнуудын гаднах хэлбэр оршуулгын зан үйл зэргийг харахад “Мөнгөн тайгын соёл”-д хамааруулан авч үзэж болно. Хэдийгээр нэг соёлын хүрээнд авч үзэж болохоор булшны гадаад хэлбэр, оршуулгын зан үйлүүд ажиглагдаж буй боловч эдгээр нь “Мөнгөн тайгын соёл”-ыг үлдээгчдийн угсаа-соёлын уламжлалын нэг хүрээнд, нэг цаг хугацаанд амьдарч байсан эртний овог аймгуудын нийтлэг соёлын дурсгалууд Алтай-Соёны нутгаар түгээмэл тархалттай байгааг судлаачид анхааран тэмдэглэжээ (Семенов, Чугунов, 1995), (Чугунов, 1994).

Бидний Монгол Алтайн бүс нутагт явуулсан судалгаанд ажиглагдсан нэг зүйл бол голын хөндийгөөс дээш, уулын хормой дагасан мөн дугуй болон дөрвөлжин хэлбэртэй, том том чулуунуудаар булшны дараас чулуунуудаа хашиж хүрээлсэн, дөрвөн буландаа босоо хөшөө чулуутай, голын дараас чулуунуудын өндөр нь 2 метр орчим булшнууд юм. Энэ хэлбэрийн булш магадгүй “Мөнгөн тайгын соёл”-ын хожуу үед хамаарах булшны байгууламж болоод оршуулгын зан үйл байж болох юм. Ховд аймгийн Мөнххайрхан сумын нутаг Хатуу даваа хэмээх газрын 3-р булш буюу дөрвөлжин хэлбэрийн өндөр чулуун дараастай булш (**Зураг 13**), Адуучийн ам хэмээх газар малтсан 1-р булш өндөр чулуун дараастай дугуй хэлбэрийн булшнуудыг малтан шинжлэх үед оршуулгын чулуун хашлагануудын зууван дугуй хэлбэрээр хүнээ тойруулан дээш нь шатлан өрж тавиад чулуугаар таглан түүнийгээ дээш овойлгон чулуун дараас хийсэн болох нь тодорхой байна. Ийм хэлбэрийн булшийг 1960-аад онд В.Волков, Ц.Доржсүрэн нар малтсан тухай мэдээ байна (Батмөнх., 2000). Бидний малтсан Хатуу давааны 3-р булшны оршуулгын зан үйлд толгойг нь зүүн тийш хандуулан тавьсан хүүхдийн оршуулга илэрсэн бол Адуучийн амны 1-р булшинд насанд хүрсэн эрэгтэй хүнийг баруун хажуугаар нь агийлган хэвтүүлээд толгойг нь баруун тийш хандуулан тавьжээ. Энэ хоёр булшны яснаас авсан радио-карбоны лабораторийн задлан шинжилгээгээр хүүхдийн оршуулга МЭӨ II мянган жилийн II хагаст холбогдоно хэмээн гарч байхад насанд хүрсэн эрэгтэй хүний оршуулгын зан үйл МЭӨ 800-360 жилийн тэртээд холбогдоно хэмээн тодорхойлсон байна. (Эдгээр шинжилгээнүүдийг Санкт-Петербургийн Эдийн соёлыг судлах хүрээлэнгийн лабораторид хийсэн болно. Le-6940).

Хар говийн дугуй хүрээтэй хиригсүүрийн цэвэрлэгээнээс өмнө харагдаж буй байдал нь намхавтар дараас чулуу бүхий дугуй хүрээний захын чулуунууд нь ил харагдаж байв. Дугуй хүрээний гадна талд дагуул тахилын байгууламжийн байдал бүрэн харагдахгүй байлаа. Өнгөн хөрсний цэвэрлэгээг хийж дуусах үед дугуй хүрээний гадна талд буюу хойд талд нь арван гурван ширхэг тахилын байгууламжууд хагас дугуй хэлбэрээр тойрон байгаа нь харагдаж байв. Дугуй хүрээтэй хиригсүүрийг бүхэл талбайгаар нь цэвэрлэж үзэхэд уг хиригсүүрийн анхны хэлбэр дүрс тодорч, эртний хөрсөн дээр дугуй хүрээтэй хиригсүүрийг 23 метр дугуй голчтой, 1 метр өргөнтэй, зарим газраа хоёр үе, зарим газраа гурван үе

чулуу давхарлан өрсөн дугуй хүрээ бүхий 2 метр өндөр овоолго дараас чулуутай (**Зураг 17**), голын дараас чулуу болон хиригсүүрийн 1 метр өргөнтэй дугуй хүрээг холбон 13 цацрагийг чулуугаар өрж хийсэн нь энэ хиригсүүрийг дээрээс харахад тэрэгний дугуй, хүрд мэт эсвэл нар мэт харагдахаар барьж хийсэн байна. Хиригсүүрийн хойд талд хагас дугуй хэлбэртэйгээр цувуулан байрлуулсан 13 ширхэг дугуй хэлбэрийн дагуул тахилын чулуун байгууламжуудыг 1-1,5 метрийн дугуй голчтойгоор хийсэн байна (**Зураг 15**). Хиригсүүрийн голын овоолго дараас чулууны хөндлөн голч нь 13 метр дугуй голчтой, 2 метр өндөртэй байна. Хиригсүүрийн дугуй хүрээний баруун талд 1 метр дугуй голчтой хоёр дагуул чулуун байгууламжийг мөн хийсэн байна.

Монгол нутагт өмнө археологийн хайгуул судалгааны явцад хиригсүүрийн төрлийн булш, тахилгын байгууламжуудын хэлбэрийг тэр бүр нарийвчлан судалж байгаагүй. Харин Оросын археологич Э.А.Новгородова дөрвөлжин, дугуй хүрээтэй боловч дагалдах байгууламж нь янз бүрийн хэлбэртэй харилцан адилгүй дүрстэй жар гаруй хэлбэр байгааг малтлагын бус ажиглалтын судалгаагаар тэмдэглэсэн байна (Новгородова, 1989). Түүнчлэн сүүлийн жилүүдэд Монгол болон БНХАУ, ОХУ-ын Алтайн нурууны бүс нутагт явуулсан археологийн судалгааны үр дүнд тулгуурлан зарим хиригсүүр голын дараас чулууны зүүн талаас “сахал” хэлбэртэй чулуун өрлөг байгааг анхааран нэг хэлбэр болгон авч үзсэн судалгаа бас байдаг (Hayashi, 2000). 1990-ээд оноос хиригсүүрийн дурсгалыг малтан шинжлэх ажил нилээд эхэлж дугуй болон дөрвөлжин хүрээтэй хиригсүүрийг цөөн биш малтан шинжилсэн бөгөөд зориулалтаар нь оршуулгын болон тахилгын байгууламж хэмээн хоёр ерөнхий ангилал хийсэн судалгаа бий (Эрдэнэбаатар, 2002). Мөн хиригсүүрийн гаднах байгууламжуудыг дугуй хүрээтэй болон дөрвөлжин хүрээтэй гэдгээр хоёр төрөл болгон, хүрээтэй хиригсүүрүүдийг голын чулуун дарааснуудтай холбосон чулуун өрлөгүүдийг дэд хэлбэрт хамааруулан, нэмэлт чулуун байгууламжуудыг дахин ангилахаас гадна чулуун хүрээн дээрхи чулуу хөшөөтэй байгууламжуудыг нэг тусдаа ангилал хийж үзсэн судлаачид бий (Савинов, и др., 2007; Урантугс, 2007). Монгол болон Байгал нуур хавийн бүс нутагт малтан шинжилсэн хиригсүүрийн дурсгалуудыг, Алтайн нурууны бүс нутагт орших хиригсүүрийн дурсгалуудтай харьцуулан үзэхэд угсаа-соёлын гол шинжүүд нэг нь нөгөөгөөсөө их ялгарах шинжгүй нэг угсаа-соёлын овог аймгийнхан үлдээсэн болох нь тодорхой харагдаж байна. Хар говийн буган чулуун хөшөө бүхий дугуй хүрээтэй хиригсүүрийн өнгөн хөрсний цэвэрлэгээний дараа зүүн талаас нь харсан ерөнхий байдлын гэрэл зураг дээр дугуй хүрээний давхар үе болон дугуй хүрээнээс голын овоолго дараас чулуу хүртэл холбосон цацрагийг жижгэвтэр чулуунуудаар өрж хийхдээ голын дараас чулууны зах хүрсэн хэсгийн өргөн 2 метр, дугуй хүрээний зах хүрсэн хэсгийн өргөн нь 1 метр байна. Хиригсүүрийн баруун талаас харсан байдал дугуй хүрээний баруун захад нэг жижиг дагуул чулуун байгууламжийг тулган байгуулсан байна. Хиригсүүрийн хүрээг хийхдээ чулууг ихэвчлэн нэг эгнээгээр, давхарлан өрөхгүйгээр хийдэг бол Хар говийн энэ дугуй хүрээтэй хиригсүүрийн хүрээг 1 метр өрчин өргөнтэйгээр, хоёроос гурван үе давхарлан өрж хийсэн байдал ажиглагдаж байгаа нь хиригсүүрийн гадаад зохион байгуулалтын бүтцийг цаашид улам анхааралтай авч үзэх хэрэгтэйг харуулж байна. Хиригсүүрийг ийм байдлаар барьж байгуулах хэлбэр магадгүй Алтайн бүс нутгийн онцлог байж болох талтай. Хиригсүүрийн зүүн хойт талаар хагас дугуй тойрсон 13 ширхэг дагуул дугуй чулуун байгууламжууд малтлага цэвэрлэгээний явцад мал амьтан дагалдуулсан юм уу хойлголсон шинж мэдэгдээгүй боловч тэдгээр нь 1-рт нилээд хэсэг нь гадаад хэлбэр нь эвдэрч тоногдсон байдалтай, үндсэн төрхөө алдсан бол зарим бүтэн

байгаа дагуул байгууламжуудад мал амьтны яс илэрсэнгүй. 2-рт тайлга тахилга үйлдсэн цагаас хойш олон мянган жил өнгөрсөн учраас бага малаар хойлго, тахилга үйлдсэн тохиолдолд мал амьтны яс үлдэх нь ховор байх магадлалтай. Төв болон умард Монголын Хангайн нурууны бүс нутаг дахь хиригсүүрүүдийг малтан шинжлэх явцад дугуй болон дөрвөлжин хүрээтэй хиригсүүрийн хүрээний гадуур байх ийм дугуй чулуун тахилгын байгууламжуудад адууны толгой, хүзүү, туурайн яс гарах нь (Эрдэнэбаатар, 2002) түгээмэл байдаг. Хар говийн энэхүү буган чулуун хөшөө бүхий дугуй хүрээтэй хиригсүүрийн хүрээний гадна орших 13 тахилын байгууламжаас мал амьтны яс илэрч олдсонгүй. Мөн эрт үед тоногдон үрэгдсэн байж болох юм.

1-р дагуул дугуй чулуун байгууламж: Ерөнхий хэлбэр төрх эвдэрч, чулуунууд нь зөв биш байрлалтай болсон бөгөөд уг дагуул байгууламжийг цэвэрлэж үзэхэд малын яс болон эд өлгийн зүйл илэрсэнгүй дуусав. Тойруулан тавьсан чулуунууд зууван дугуй хэлбэртэй, голч метр нь 0,80-1 метрийн харьцаатай байна.

2-р дагуул дугуй чулуун байгууламж: Энэ дагуул байгууламж маш их эвдэрч, тойрсон чулуунуудын, зургаан ширхэг чулуу нь үлдэж бусад чулуунууд нь алга болсон байна. Тойруулан тавьсан чулуунуудын голч метрийг тодорхойлох боломжгүй байна.

3-р дагуул дугуй чулуун байгууламж: Уг байгууламж бүр мөсөн эвдэрч анхны хэлбэр төрхөө нэгэнт алдсан, тойруулан тавьсан чулуунуудаас дөнгөж гурван чулуу үлджээ. Тойруулан тавьсан чулууны голч метрийг тодорхойлох боломжгүй болсон байна.

4-р дагуул дугуй чулуун байгууламж: Энэ байгууламж бас бүрэн эвдэрч тойруулан тавьсан чулуунуудаас таван ширхэг чулуу үлдсэн байна. Тойрог чулууны голч метрийг тодорхойлох боломж байсангүй.

5-р дагуул дугуй чулуун байгууламж: Энэ дагуул байгууламжийн анхны хэлбэр мөн нэгэн адил эвдэрч нурсан хэдий боловч чулуунууд нь ерөнхийдөө зуувандуу дугуй хэлбэрээр тарж байрласан байна. Цэвэрлэгээг бүрэн хийж дуусах үед газрын хөрсөн дээр гурван хэсэг газар шатсан нүүрсний үлдэгдэл илэрч мэдэгдэв. Тойруулан тавьсан чулуунуудын голч метр нь 1,6 метр орчим байсан бололтой байна.

6-р дагуул дугуй чулуун байгууламж: Уг дагуул байгууламж мөн бүрэн эвдэрч нурсан байх бөгөөд есөн ширхэг чулуу тарж бутарсан байдалтай харагдаж байв. Дагуул байгууламжийг бүрэн цэвэрлэж дуусах үед хоёр хэсэг газар шатсан нүүрс, ясны үлдэгдэл хэсэг илэрч олдов. Тойруулан тавьсан чулуунуудын голч метр 2,2 метр орчим хэмжээтэй байсан бололтой.

7-р дагуул дугуй чулуун байгууламж: Энэ дагуул байгууламж бас бүрэн эвдэрч тойруулан тавьсан чулуунууд үндсэндээ байхгүй шахам болсон бөгөөд зургаан ширхэг чулууны дөрөв нь нэг шугаманд зэрэгцсэн, хоёр чулуу нь тарсан, хоорондоо нилээд хол зайтай байна. Тойруулан тавьсан чулууны голч метр нь 1,5 метр орчим байсан бололтой.

8-р дагуул дугуй чулуун байгууламж: Уг дагуул байгууламж бас бүрэн эвдэрч нурсан бөгөөд зөвхөн таван ширхэг чулуу үлдсэн бөгөөд дагуул байгууламжийн гол хэсэгт шатсан нүүрсний үлдэгдэл илэрч мэдэгдэв. Тойруулан тавьсан чулууны голч метр нь 1,2 метр орчим байна.

9-р дагуул дугуй чулуун байгууламж: Энэ дагуул байгууламж ерөнхийдээ тойруулж тавьсан чулуунууд бүтэн, үндсэн дугуй хэлбэрээ хадгалан үлдсэн боловч хоёр хэсэг газар чулуу нь үгүй болсон, цэвэрлэгээг хийж дуусах үед тойрог чулуунуудын захад шатсан нүүрсний үлдэгдэл илэрч мэдэгдэв. Тойруулан тавьсан чулууны голч метр нь 2 метр байна.

10-р дагуул дугуй чулуун байгууламж: Энэ дагуул байгууламжийн тойруулж тавьсан чулуунуудын ерөнхий хэлбэр хадгалагдан үлдсэн боловч зарим газраа нэг, хоёр чулуу дутуу байна. Бүрэн цэвэрлэгээ хийж дуусах үед мал амьтны яс, нүүрс илэрч мэдэгдээгүй. Тойруулан тавьсан чулууны голч метр нь 1,5 метр байна.

11-р дагуул дугуй чулуун байгууламж: Уг дагуул байгууламжийн урд, хойт хэсэгт нэгээс хоёр чулуу байрнаасаа хөдлөн байхгүй болсон бөгөөд байгууламжийн үндсэн хэлбэр төрх мэдэгдэж буй боловч цэвэрлэгээний явцад дотроос нь мал амьтны яс, нүүрс илэрч мэдэгдсэнгүй. Тойрог чулууны голч метр, 1 метр байлаа.

12-р дагуул дугуй чулуун байгууламж: Энэ дагуул байгууламжийн тойруулж тавьсан чулуунуудын үндсэн байрлал ерөнхийдээ бүтэн боловч цэвэрлэгээний явцад тайлга, тахилга хийсэн ул мөр мэдэгдсэнгүй. Тойруулан тавьсан чулууны голч метр нь 1 метр байна.

13-р дагуул дугуй чулуун байгууламж: Уг дагуул байгууламжийн анхны байрлал бүтэн боловч ганц нэг чулуу дутуу байна. Бүрэн цэвэрлэгээ хийж дуусах үед тайлга, тахилга хийсэн ул мөр илэрч мэдэгдсэнгүй. Тойрог чулууны голч метр нь 1 метр байна.

Энэхүү Хар говийн буган чулуун хөшөө бүхий хиригсүүрийн дугуй хүрээг 1 метрийн өргөнтэй, 30-50 см-ийн өндөртэйгээр хоёроос гурван үе чулуу давхарлан өрж хийсэн байх бөгөөд хүрээ чулууны баруун хойт хэсэгт 1-р үеийн чулуун өрлөгийн сууринд дутуу засаж орхисон буган чулуун хөшөөний зэхэцийг өрлөгт ашигласан байна. Уг чулуу 1 метр урттай, үзүүрийн хэсгийг гонзгойлон зассан байна. Хар говийн буган чулуун хөшөө бүхий дугуй хүрээтэй хиригсүүрийн голын овоолго, дараас чулуунуудыг таллан хөндлөн огтлол хийж, цэвэрлэгээг хийсэн бөгөөд голын дараас чулууг газар дээр тойруулан тойрог хүрээ гарган, дээш шатлан өрсөн болох нь тодорхой харагдаж байна. Ингэж дээш шатлан өрөхдөө оршуулга, тахилганд зориулж голд нь зай үлдээсэн байна. Дээд үеийн шатлан өрсөн чулуун өрлөгийн дотор хөндий зайд буй шороог зайлуулан цэвэрлэж үзэхэд 2,5 метр өргөн, 1,7 метр урттай хөндий зай байгаа мэдэгдсэн болно. Энэ хөндий зайн зүүн хэсгээс хүний хөлийн шилбэний яс, бас нэг буган чулуун хөшөөг зэрэгцүүлэн цуг тавьсан нь илэрч олдлоо. Энэхүү зууван дугуй хэлбэрээр өрж байгуулсан хөндий зайг тойруулан өрсөн чулуун өрлөгийн хэмжээ 2 метр өргөн, 3,5 метр урттай байлаа. Уг хиригсүүрт буган чулуун хөшөөг хүнтэй хамт оршуулсан болох нь тодорхой байв. Хүний яс бүрэн тоногдож үгүй болсон боловч шилбэний ясны байрлалаас харахад хүнийхээ толгойг баруун тийш хандуулан тавьж оршуулсан бололтой. Оршуулгын хөндий зайд байсан буган чулуун хөшөөний урт 1,1 метр, урд болон хойт талын өргөн 35 см, баруун болон зүүн хоёр хажуу нь 25 см өргөнтэй байна. Энэхүү буган чулуун хөшөөний нүүрэн талд ташуу гурван зураа, түүний дор хүзүүний зүүлтний дөрвөн эрх, доод талд нь жижиг чичлүүр хутга дүрслэн үзүүлсэн байна. Зүүн талд ээмэг, хүзүүний зүүлтний дөрвөн эрх, саадагтай нум, нэг морь, баруун талд нь ээмэг, хүзүүний зүүлтний гурван эрх, жижиг цоолтуур сүх, ар талд нь хүзүүний зүүлтний таван эрхийг тус тус дүрсэлжээ.



Зураг 15. Ховд Мөнххайрхан сум,
Тэлэнгэдийн амны хиргисүүрийн оршуулгын
зан үйл



Зураг 16 Ховд Мөнххайрхан сум,
Хар говийн Буган чулуун хөшөөтэй
хиргисүүр



Зураг 17. Ховд Мөнххайрхан сум, Хар говийн
хиргисүүрийн хажуугийн байдал



Зураг 18. Ховд Мөнххайрхан сум,
Хар говийн хиргисүүрээс олдсон
буган хөшөө



Зураг 19. Ховд Мөнххайрхан сум,
Хар говийн хиргисүүрээс олдсон
ваарны хагархай



Зураг 20. Ховд Мөнххайрхан сум, Хар говийн
хиргисүүрээс олдсон чулуун зэвсэг



Зураг 22 Ховд Үенч сум Байтагийн булш



Зураг 23 Ховд Үенч сум Байтагийн булшны
оршуулгын зан үйл



Зураг 24. Дөрвөлжин булш



Зураг 25. Буган хөшөөтэй дөрвөлжин булш



Зураг 26. Шоргоолжин булш



Зураг 27. Шоргоолжин булшны хашлага

В.Волков 1981 онд хэвлүүлсэн “Оленные камни” бүтээлдээ Ховд аймгийн Мөст сумын Харговь гэдэг газраас олдсон гэж тайлбарласан нэг буган хөшөө (Волков, 1989; 2000) уг хөшөөтэй адил төстэй боловч, нүүрний ташуу зураа нь хоёр ширхэг, нумын хажууд морь байхгүй байгаагаараа ялгаатай байна. Энэ хиригсүүрийн малтлагаас нийтдээ таван буган чулуун хөшөө олдсон бөгөөд нэг хөшөө нь буган чулуун хөшөө хийхээр зэхсэн бэлдэц, нөгөө дөрвөн хөшөөний хоёр хиригсүүрийн гадна босоо байсан бол, хоёр буган чулуун хөшөөний нэг нь голын дараас чулууны дунд, нөгөө нь оршуулгын чулуун байгууламж дотор тус байв (Зураг 14, 3-р болон 4-р гар зураг). Мөн хиригсүүрийн малтлагаас хүрэн бор өнгийн ваарны хагархай хэсэг, нэг чулуун сүх зэрэг зүйл олдсон юм. Уг хиригсүүрийн гаднах байгууламжийн бас нэг онцлог нь урьд өмнө монгол нутагт малтан шинжилж байсан хиригсүүрүүдээс өвөрмөц хэлбэртэй, голын дугуй чулуун дараас, хүрээ чулууг холбон жижиг чулуунуудаар 13 хигээс цацраг хийж тавьсан байв. Мөн дугуй хүрээний гадна зүүн талд хагас дугуй хэлбэртэй цувуулан тавьсан дугуй дагуул байгууламж мөн 13 ширхэг байна. Бид хиригсүүрээс чанх урагшаа 20 метр зайд орших 1-р буган чулуун хөшөө бүхий жижиг тахилын байгууламжийг малтан шинжилж үзсэн боловч тахилын зүйл олдоогүй харин хоёр чулуун зэвсэг олдсон юм. Мөн уг дурсгалыг урьд нь малтан шинжилсэн ул мөр мэдэгдсэн учраас бид В.Волковын хийсэн малтлагын ором гэж үзсэн болно. Эртний болон өнөөгийн монголчуудын дунд нилээд түгээмэл байдаг сайн тооны билэгдэл 13 байдаг. Энэхүү сайн тооны билэгдэл 13 уг хиригсүүрийн байгууламжид тод ажиглагдаж байгаа нь зүгээр нэг тохиолдол биш нь ойлгомжтой. Хиригсүүрт оршуулсан хүний нас хүйсийг хэдийгээр тодорхойлох боломж одоогоор байхгүй байгаа боловч уг хиригсүүртэй хамт байгаа буган чулуун хөшөөнүүд болон хиригсүүрийн дугуй хүрээ бүхий байгууламжийг эртний монгол эрэгтэй, эмэгтэй хүнийг билэгдэж байдаг дүрсийн билэгдэлтэй харьцуулан авч үзвэл Хар говийн буган чулуун хөшөө бүхий хиригсүүр эмэгтэй хүний оршуулга байх магадлал байгаа юм. Ийнхүү эмэгтэй хүний булш байж магадгүй хэмээн үзэж буй гол үндэслэл бол 1-рт

монголчуудын эрэгтэй хүний билэгдэл дөрвөлжин дүрс, эмэгтэй хүний билэгдэл дугуй дүрс байдаг, тухайлбал, монголчууд уг хоёр дүрсийг хаан сүйх, хатан сүйх хэмээн нэрлэдэг, 2-рт В.Волковын хийсэн буган чулуун хөшөөний гурван ангилал болох 1. Евроазийн хэлбэр, 2. Алтай-Соёны, 3. Монгол-Байгалийн гэсэн ангилал (Волков, 1981) нь буган хөшөөнд гаргасан дүрслэл, хэлбэрийг харьцуулан гаргасан ангилал бол, миний бодлоор буган чулуун хөшөөг ангилсан дээрх ангиллыг залгуулан буган чулуун хөшөөний дүрслэл нь эрэгтэй, эмэгтэй хүнийг ялган дүрсэлсэн гэж үзэх үндэслэл байна. Тиймээс Монгол-Байгалийн хэлбэрийн дүрслэл бүхий буган чулуун хөшөө эрэгтэй хүнийг, Алтай-Соёны болон Евроазийн хэлбэрийн дүрслэл бүхий буган чулуун хөшөө эмэгтэй хүнийг билэгдэн үзүүлсэн бололтой байна. Учир нь Монгол-Байгалийн хэлбэр бүхий буган чулуун хөшөө нь эрэгтэй хүний хэрэглэдэг эдлэл хэрэглэл болох бүс, зэр зэвсэг, бамбай, гоёл чимэглэл зэргийг дүрслэн үзүүлсэн бол Алтай-Соёны болон Евроазийн хэлбэр




Figure 1
Deer stone tree types from Mongolia and Siberia
(by Novgorodova, 1989)

бүхий буган чулуун хөшөө нь ихэнхдээ эмэгтэй хүний эдлэл хэрэглэл хүзүүний зүүлт, жижиг чичлүүр хутга, нүүрний ташуу хос буюу гурвалсан зураасыг дүрслэн үзүүлсэн байдаг байна. Буган хөшөөний гол үндсэн дүрслэл болох бугыг гаж домгийн хэлбэрээр дүрслэх нь тухай цагийн овог аймгийн хүмүүсийн бие дээр шивсэн шивээс болох нь сүүлийн үеийн археологийн судалгаанаас тодорхой байна.

Ийм санааг археологич Д.Баяр өөрийн судалгааны өгүүлэлдээ дурьдсан байдаг (Баяр, 1995). Сүүлийн жилүүдэд Хангай болон Алтайн бүс нутагт явуулж буй археологийн хайгуул, малтлага судалгааны явцад буган чулуун хөшөө болон хиригсүүрийн дурсгал оршин байгаа газруудад Монгол-Байгалийн болон Алтай-Соёны хэлбэр бүхий буган чулуун

хөшөөнүүд хамтдаа байгаа нь тодорхой байхаас гадна хиригсүүрийн булшны чулуун байгууламж дотор Монгол-Байгалийн болон Алтай-Соёны хэлбэрийн буган чулуун хөшөө хоёроос доошгүй хамт байх нь тохиолдож байна. Энэ нь буган чулуун хөшөөний В.Волковын хийсэн ангилал ёсоор Евроази болон Алтай-Соёны хэлбэрийн буган чулуун хөшөө эрт үеийнх, Монгол-Байгалийн хэлбэрийн буган хөшөө хожуу үеийнх (Волков, 1981) гэдэг юм уу зарим судлаачдын үзэж буйгаар Монгол-Байгалийн хэлбэрийн буган чулуун хөшөө нь эрт үеийнх Евроази болон Алтай-Соёны хэлбэрийн буган хөшөө хожуу хүрлийн үеийнх (Цэвээндорж, 1979) гэсэн цаг хугацааны хувьд ангилал хийх гэсэн санааг эргэж харууштай санагдана. Хар говийн буган чулуун хөшөө бүхий хиригсүүрийн голын хүн оршуулж орхисон чулуун хайрцагнаас гарсан хүний ясан дээр хийсэн радио-карбоны задлан шинжилгээний дүнгээс харахад МЭӨ 1200-750 жилийн тэртээд холбогдоно хэмээн гарчээ. (Эдгээр шинжилгээнүүдийг Санкт-Петербургийн Эдийн соёлыг судлах хүрээлэнгийн лабораторид хийсэн болно. Le-6931)

Төв болон зүүн хойт Ази, Сибирийн эртний хүрэл-төмрийн үеийн овог аймгуудын соёлын хэлхээ холбооны уламжлалыг мөшгөн хөөж үзвэл ялангуяа

соёлын генетик холбоо угсаа-гарал хамаарахгүйгээр бие биендээ нөлөөлсөн байхыг үгүйсгэх аргагүй юм. Тийм учраас сүүлийн жилүүдэд Оросын болон Монгол Алтайгаас илэрч олоод байгаа Пазырыкчуудын булшнаас гарч буй хүний бие дээрхи өнгө алаглан шивээс хийдэг, тэдгээр шивээс нь тухай цагийн соёлын гол үндсэн шинж болох буга, тураг зэрэг амьтныг загварчлан дүрслэн үзүүлж буй зэрэг нь тэднээс өмнө Монгол Алтай болон Хангайн бүс нутгаар нутаглан амьдарч байсан хиригсүүр, буган чулууг үлдээгчид мөн нэгэн адил бие дээрээ бугыг шивээслэн дүрсэлж байсны ул мөр, хүнд зориулан босгосон тэрхүү буган чулуун хөшөөнд илэрч байгаа бололтой. Алтай-Соёны хэлбэрт хамаарах буган чулуун хөшөөнд бүс ховор дүрсэлдэг бөгөөд зарим үед нарийн бүс дүрсэлсэн байдаг боловч тэр нь цэрэг эрсийн бүс биш жижиг ахуйн хүрээнд хэрэглэдэг чичлүүр хутга зүүсэн нарийн бүс дүрсэлсэн байх нь олонтой байна.

Монгол Алтайн өвөр хэсэгт хожуу хүрэл зэвсгийн үед соёлын өөр шинж бүхий эртний овог аймгууд байсан болох нь тодорхой, археологийн дурсгалууд илэрч олоод буйг энд тэмдэглэх хэрэгтэй. 2005 онд бидний явуулсан судалгааны ажлын явцад Ховд аймгийн Үенч сумын нутаг Байтаг богд уулын Улиастайн гол хэмээх газар Улиастайн дунд дэнж-1 гэж нэрлэсэн газраас долоон цагираг хэлбэрийн 1,7-2,2 метр дугуй голчтой нэг үе чулуун өрлөг бүхий хүрээнүүд илэрч олдсон юм. Хэдийгээр эдгээр булшнууд маш их тоногдон эвдэрсэн боловч оршуулгын зан үйл нь хүнийхээ толгойг нь зүүн тийш хандуулан, нуруугаар дээш харуулан хэвлүүлэхдээ, өвдгийг нь дээш босгон нугалсан байдалтай болох нь тодорхой байна. Ийм оршуулгын зан үйл бүхий булш (**Зураг 22**) Ховд аймгийн Булган сумын нутаг Хөх үзүүр гэдэг газраас олдсон бөгөөд Үенч сумын нутаг Байтаг уул (**Зураг 23**) хүртэл үргэлжилсэн 200 гаруй км зайд тархсан “Байтагийн соёл” хэмээн бидний нэрлэсэн энэхүү соёлын дурсгалын холбогдох он цаг нь МЭӨ 1400-200 жилийн тэртээд холбогдоно гэж радио-карбоны задлан шинжилгээний дүнгээр гарсан байна. (Эдгээр шинжилгээнүүдийг Санкт-Петербургийн Эдийн соёлыг судлах хүрээлэнгийн лабораторид хийсэн болно. Le-7216, Le-7223,)

Монгол орны баруун болон баруун өмнөд хэсгийн нутгаас олдсон эдгээр археологийн дурсгалууд нь хүрэл зэвсгийн нэн эртний үеэс эхлэн хожуу хүрэл зэвсгийн үе тухайлбал хүннү нарын үеийг хүртэл угсаа-соёлын залгамж холбоог ямар нэг байдлаар хадгалсаар ирсэн байна. Төв болон зүүн бүсийн нутгаар одоо бидний судалгаанд тодорхой мэдэгдэж буй нь дөрвөлжин булшны соёлыг үлдээгч аймгууд юм. Энэхүү соёлыг үлдээгчид нь хавтгайдуу чулуугаар тэгш дөрвөлжин хэлбэрийн хашлага бүхий чулуун байгууламжийг урт талаар нь зүүн-баруун чиглэлтэй өрж тавиад (**Зураг 24, 25**), уг байгууламж дотроо хүнээ оршуулахдаа газрын хөрсөнд гүн биш нүх ухаж, хүнээ зүүн тийш хандуулан тэнэгэр байдлаар тавихдаа чулуун хайрцаг хийх буюу зүгээр нүхэнд шороогоор дүүргэн хөл, толгойд нь чулуу дэрлүүлэх буюу эд өлөг дагалдуулан тавих ёс заншилтай байдаг.

Дөрвөлжин булшны соёлыг үлдээгчид нь МЭӨ II мянган жилийн тэртээгээс өдгөөгийн Хангайн нурууны бүс нутагт баруун талаас зүүн тийш нүүдэллэж байсан буган чулуун хөшөө бүхий хиригсүүрийн соёлыг үлдээгч нартай уулзан зарим үед хил залган эв найртай амьдарч байсан боловч зарим үед хэн хэнийгээ баруун, зүүн тийш хөөн нутаг дэвсгэр, эзэмшлээ булаалдан байхдаа олон овог аймгуудыг өөртөө нэгтгэн бас алдаж байжээ. Буган чулуун хөшөө бүхий хиригсүүрийн зүүн зах өдгөөгийн Хэнтий аймгийн Батширээт, Биндэр сумын заагт оршин байна.

Сүүлийн жилүүдэд монгол нутагт явуулж буй археологийн хээрийн шинжилгээний ангиудын судалгаагаар өдгөөгийн Монгол орны төв болон өмнө зүгийн нутгаар “шоргоолжин булш” хэмээх галбирт булшийг үлдээсэн (**Зураг 26, 27**) өөр угсаа-соёлын онцлог бүхий овог аймаг байсан болох нь тодорхой болоод байна. Энэ соёлыг үлдээгч нар нь одоогийн Төв, Дундговь, Өмнөговь, Баянхонгор аймгуудын нутгаар нутаглаж байсан, буган чулуун хөшөө бүхий хиригсүүрийн соёл, дөрвөлжин булшны соёлыг үлдээгч эртний овог аймгуудтай зэрэгцэн оршиж байсан бололтой.

“Шоргоолжин булш”-ны соёлыг үлдээгч нарын тухай өмнө нь судалсан зарим эрдэмтэд “Дөрвөлжин булш”-ны соёлыг үлдээгч аймгуудын үлдээсэн дөрвөлжин булшны нэг хэлбэр хэмээн авч үзсэн (Наваан, 1975) байдаг. Гэвч энэ нь одоогоос 30-20-иод жилийн тэртээд хийсэн судалгааны үр дүн бөгөөд өнөөгийн судалгааны төвшинд “шоргоолжин булш”-ны гадаад болон дотоод бүтэц зохион байгуулалт, оршуулгын зан үйл зэргийг “дөрвөлжин булш”-ны оршуулгын зан үйл, гадаад, дотоод зохион байгуулалттай харьцуулан үзэхэд нэг нь нөгөөгөөсөө эрс ялгаатай өөр соёлыг үлдээгч овог аймаг болох нь тодорхой байна.

Нэн эрт үеэс тухайлбал чулуун зэвсгийн дунд үеэс өнөөгийн монгол орны нутагт оршин байсан эртний хүний соёлын ул мөрийг мөшгөн хөөж үзвээс хүний амьдралын дараах “мөч” нөгөө ертөнцөд байх тэр “гэр орон”-г чулуугаар барьж байгуулах нь бүхэл бүтэн соёл болж төлөвшсөн байна. Тиймээс ч Монголчууд өдгөө хүртэл төрөхөд “хүй дарсан чулуу” хэмээн хүндэлдэг чулуу байхад, насанд хүрч гэр бүл болон хурим найр хийхэд бэрийн хормой дээр “бэр суусан газраа, чулуу шидсэн байрандаа” хэмээн бэрийн хормой дээр чулуу тавьдаг заншил бий бөгөөд энэ нь бэрийг тухайн айлын үндсэн гишүүн болсныг баталж өгдөг ёс юм. Эцэст нь хүн хорвоогийн амьдралыг орхин нас барахад чулуугаар толгой, хөлд нь дэр хийж, чулуугаар дарж орхидог нь “газар эх”-дээ үүрд шингэхийн бэлэгдэл болдог байна.

НОМ ЗҮЙ

- Батмөнх Б.*, 2000. Ховд аймгийн нутаг дахь эртний түүх соёлын дурсгал. УБ. т. 160
- Баяр Д.*, 1995. Монгол-Алтайд шинээр олдсон зарим буган хөшөөний тухай. Археологийн судлал. Том ХҮ. Fasc.Ү. УБ. х. 53-64, 95-р тал
- Волков В.*, 1981. Оленные камни. УБ. с. 227
- Волков В.*, 2002. Оленные камни. М., с. 219
- Елин В.Н., Эрдэнэцогт Р., Батмөнх Б., Баяраа Д.*, 1994. Раскопки на могильнике Овоот в Монголии. Проблемы изучения культурно-исторического наследия Алтая. Горно-Алтайск, с. 22-24
- Ковалев А.А.*, 2005. Чемурачский культурный феномен: его происхождение и роль в формировании культур эпохи ранней бронзы Алтая и Центральной Азии. Западная и Южная Сибирь в древности. Барнаул, Изд-во Алт. Ун-та. с. 178-184
- Коновалов П.Б., Наваан Д., Волков В.В., Санжмятав Т.*, 1995. Керексуры в Тосонцэнгэ (р. Идэр, Монголия). Культуры и памятники бронзового и раннего железного веков Забайкалья и Монголии. Улан-Удэ, с. 47-58
- Наваан Д.*, 1975. Дорнод Монголын хүрлийн үе. УБ.
- Новгородова Э.А.*, 1989. Древняя Монголия. М. с. 213-218
- Савинов Д.Г., Урантугс С.*, 2007. Опыт типологии херексуров. Алтае-Саянская горная страна и история освоения ее кочевниками. Барнаул, с.142-145
- Семенов В.А., Чугунов К.В.*, 1999. Роль субстрата в сложении культур скифского облика в Туве. Проблемы археологии степной Евразии. Тез.докл. Кемерово, Кемер. ун-та, Т. I. с.180-185

- Тишкин А.А.*, 2006. Археологические обследования на Алтае и в Монголии. Проблемы археологии, этнографии, антропологии Сибири и сопредельных территорий. Новосибирск, Изд-во Ин-та археологии и этнографии СО РАН, Т. XII, ч. I . с. 489-492
- Урантугс С.*, 2007. Историко-археологическое изучение западной Монголии (Эпоха бронзы-скифское время). Автореферат, СПб.
- Цэвээндорж Д.*, 1979. Монгол нутгаас олдсон зарим буган хөшөө. Археологийн судлал. SA, Т.ҮII. Fasc.13. УБ.
- Чугунов К.В.*, 1994. Монгун тайгинская культура эпохи поздней бронзы Тувы (типологическая классификация погребального обряда и относительная хронология). Петербургский археологический вестник.. СПб., 18, с. 43-53
- Эрдэнэбаатар Д.*, 2002. Монгол нутаг дахь дөрвөлжин булш хиригсүүрийн соёл. УБ. т. 126-143
- Kovalev A.A.*, 2000. Die ältesten Stelen am Ertix. EURASIA ANTIQUA Bd. 5(1999). S. pp.135-178.
- Hayashi Toshio*, 1999. Distribution of Kurgan's "with Moustaches". p. 2-24, 409-461.
- Hayashi Toshio*, 2005. Stone Statues in Eurasia. p. 161-163.

SUMMARY

D.Erdenebaatar, A.A.Kovalev

ARCHAEOLOGICAL CULTURES OF THE MONGOLIAN ALTAI-SOYON MOUNTAIN RANGE

Since 2000, within Mongolian-Russian joint research project "Central Asian Archaeological Research", joint research team carried out vast archaeological survey and excavation of archaeological monuments from Bronze-Iron Age in Khovd and Bayan-Olgii aimags, in western Mongolia and Omnogobi, Khovsgol, Zavkhan, Bayanhongor, and Ovorkhangai aimags in Central Mongolia.

During the archaeological survey the research team discovered unique archaeological monuments belonging to the "Chemurchek" and "Pazyryk" cultures from 2500 BC, the "Monkhhairhkhhan", "Tevsh", and "Mongon Taiga" cultures from 1300 BC, in the above mentioned regions of Mongolia.

In the article we give preliminary results of the archaeological investigations and new interpretation on deer stone and khirigsuur cultures. Based on obtained results of the comparative analysis of the archaeological monuments from Bronze age of Mongolia we concluded that during Bronze Age (the second millennium BC), many groups with different cultures inhabited side by side throughout the Altai-Soyon mountain range, central and western Mongolia. The same period some clans with "Skythian" cultural elements, settled in the southern part of the Altai mountain range.